2009-2010 оны овол тохиолдсон зудын гамшгийн уршгаар 8576 малчин орх малгvй болж 32756 малчин орх малын 50 хувийг алдлаа. Мон амьжиргааны эх vvсвэрээ алдсан 1400 орчим малчин орх хот суурин бараадаж нvvжээ. Зудын гамшгийн улмаас 8,143,300 мал хорогдож, нийт толийн 36.9 хувийг хvлээн авсан нь малчдын амьдралд хvнд цохилт болсон юм. Оволжилтийн хvнд цаг vед Швейцарь улсын засгийн газар, ард тvмнээс малчин тvмэнд тусламжийн гараа сунгаж 500 мянган швейцарь франкийн буцалтгvй тусламж vзvvлэн зудын хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх тослийг хэрэгжvvллээ. Тослийг “Ногоон Алт” Бэлчээрийн Экосистемийн Удирдлага тосол хэрэгжиж буй богоод зудын байдал хамгийн хvндрэлтэй байсан Архангай аймгийн Их тамир сум, Баян-Олгий аймгийн Булган сум, Говь-Алтай аймгийн Алтай, Бигэр сумд болон Завхан аймгийн 17 суманд хэрэгжvvлсэн.




Энэхvv тусламжийн тослийг хэрэгжvvлсэн хэлбэр нь аливаа гамшиг хvнд нохцолд шууд гаднаас гурил будаа зэрэг тусламж олгодгоос оороор, тусламж авах Бэлчээр Ашиглагчдын Хэсэг (БАХ)- ийн малчин оороо хэсгийнхээ хуралд оролцож хамтаараа шийдвэр гаргаж тусламж авч байгаагаараа онцлогтой. Орон нутгийн засаг захиргааны ажилтан, багийн дарга нараас бvрдэж сумын бэлчээр ашиглагчдын холбооны тэргvvнээр удирдуулсан зудын тослийг хэрэгжvvлэх ажлын хэсэг 21 сумдад байгуулагдаж

БАХ-vvдэд олгох монгийг тосол хэрэгжvvлэх гарын авлагад зовлосний дагуу БАХ бvрт олгосон юм.
Тослийг 2 vе шаттай хэрэгжvvллээ. **Yvнд:**

1. Хvмvvнлэгийн яаралтай тусламж,
2. Дараа овлийг хохирол багатай давах малчдын хамтын vйл ажиллагааг дэмжих.

Тослийн нийт санхvvжилтийн 50 хувийг нэгдvгээр шатны vйл ажиллагаанд буюу хvмvvнлэгийн яаралтай тусламжинд зарцуулж, vлдсэн 50 хувийг хоёрдугаар шат буюу дараагийн овлийг хохирол багатай давах хамтын vйл ажиллагаанд зарцуулахаар толовлосоний дагуу 12 сарын 30-ны байдлаар тослийн vйл ажиллагаа амжилттай хэрэгжиж дуусав.

Хvмvvнлэгийн тусламжинд 235,529,000 сая тогрог зарцуулсанаас 21 сумын 9174 орх хамрагдаж 93% буюу 218,946,000 тогрогийг 8794 орход бэлнээр олгож, 4% буюу 9,433,000 тогрогоор Завхан аймгийн Цэцэн-Уул, Говь-Алтай аймгийн Бигэр сумын малчид хэлэлцэн тохиролцсоны дагуу 306 орх гурил, ургамлын тос, эм тариа зэрэг ахуйн хэрэгцээний зvйл авсан байна. Хvмvvнлэгийн тусламжийг нэн ядуу, эмзэг бvлгийнхэнд хvргэхийг их анхаарч орх толгойлсон 534 эрэгтэй, 954 эмэгтэйд эхний ээлжинд тусламж олгосон нь тусламж авсан орхийн 16% байв.

Хvмvvнлэгийн яаралтай тусламжийг зохих эзэнд нь vнэн зовоор хvргэх нь ажлын хэсгийн гишvvд тодийгvй БАХ-ийн малчдын оорсдийн хариуцлагатай байдлаас ихээхэн шалтгаалж байсан богоод БАХ-ийн хуралд малчдын оролцоо сайн байсан нь энэхvv тусламжийн хуваарилалтыг шударга болоход нолоолсон.

Энэхvv тусламжийн тослийг хэрэгжvvлсэнээр тусламж авахаас гадна БАХ-н малчдын хамтаараа асуудлаа хэлэлцэх, шийдвэр гаргах, зохион байгуулалтаа сайжруулахад их дэмжлэг болсон богоод сум орон нутгийн засаг захиргаа нь сумын бэлчээр ашиглагчдын холбоо ТББ, БАХ-н зохион байгуулалтыг илvv дэмжиж нягт хамтран ажиллах эх суурийг тавьсан гэж vзэж байна.

Сумдын дарга, засаг захиргааны толоолол БАХ-уудын хурал зохион байгуулахад оролцож, малчдын дуу хоолой, санал хvсэлтийг сонсож, сэг зэм устгахад хамтран ажилласан ба тусламж хуваарилалтын аргыг ч сайшаасан юм.

Онгорсон жилийн зудын гамшиг малчдын хувьд оорсдийнхоо оволжилтийн бэлтгэлийг хэрхэн байгааг, малч ухаанаа, бэлчээрийн менежментийг хэрэгжvvлж байгаа байдлаа, малынхаа чанар хэр байгаа таньж мэдсэн хатуу ч гэсэн томоохон сургамж сургалтыг авсан гэж хэлж болох юм. ЗХБУС тосол нь малчдын энэхvv зудын сургамжаа амьдралд дахин давтахгvйгээр ирэх жилийн овлvvдийн бэлтгэлийг хангах боломжийг олгосон гэж vзэж болно. БАХ-нхээ хурал дээр ямар vйл ажиллагааг хамтран хэрэгжvvлж овлийн хахир хатуу цагийг хохирол багатай давах талаар малчид хэлэлцэж толовлогоогоо

гаргасаны дагуу ажилласан богоод дараах vйл ажиллагаанд тослийн монгоо зарцуулсан байна. Үvнд:

- *Өвс тэжээл худалдан авах*– 10 сумын 70 БАХ-н 3170 орх 292,5 тонн,
- *Хадлангийн талбай хашаалж тvvнээс байгалийн хадлан авах*– 13 сумын 98 БАХ 481 га талбайг хашаалсан, нийт хашаалсан болон хашаалаагvйгээс 14 сумын 104 БАХ 4557 малчин орх 1276 тонн,

- *Ногоон тэжээл томоохон талбайд болон өрхvvд өвөлжөө бууцныхаа хөлд тариалж хураан авах* – 11 сумын 41 БАХ 1579 орх нэгдсэн талбайд тариалсан, 2 сумын 6 БАХ-н малчид оволжооний холд ногоон тэжээл тариалсан,
- *Малын паразит өвчлөлөөс сэргийлэх тарилга туулгалтыг хамтран хийх мал угаалгын банн барих* – 2 сумын 3 БАХ-н 110 орх мал угаалгын 2 банн,
- *Худаг ус гаргасанаар намрын отрыг хамтран зохион байгуулж малаа тарга тэвээрэг авахуулах* - 6 сумын 13 БАх-н 335 малчин орхvvд 10 гар худаг, 1 гvн ормийн худаг засварлан, 3 гар худаг шинээр гаргасан,
- *Малын хашаа хороог засаж сэлбэх, хэвтэр бууцаа цэвэрлэх, хөрзөнгөө ховхлох*– Завханмандал сумын 2 БАХ-н 31 орх,

- *Малын таргалахад ташуур турахад тушаа хужир давсыг хамтран бэлтгэж малаа тэжээн тарга тэвээрэг авахуулах* – 2 сумын 24 БАХ-н 270 гаруй малчин орх, 1 орх дунджаар 131 кг эрдэс тэжээл хужир,
- *Зарим цөөн сумдад бэлчээрээ зvй зохистой ашиглахаар бэлчээрийн зам засварлаж ашиглалтгvй бэлчээрийг ашиглах* - 2 сумын 6 БАХ-н 307 малчин орх vр шимийг хvртсэн,
- *Малгvй болсон болон цөөн малтай болсон малчид төмс хvнсний ногоо тариалах*– 10 сумын 37 БАХ-н 1563 малчин орх 148 тонн томс хvнсний ногоо хураан авсан байна. 7 БАХ-н малчид ирэх жил тариалах томсний vрээ хадгалсан,

- *БАХ-ийнхээ дундын санд оруулан бага хvvтэй хэрэглээний зээл гаргаж дундын сангаа арвижуулж байна* – 6 сумын 48 БАХ-н 2075 малчин орх дундын сандаа оруулсан. Нэг орхийн оруулсан хувь хэмжээн нь 15000-24000 тогрог юм.

**Гарын авлага татах**

{pdf}images/pdfbook/tosol/100325_dzud info.pdf{/pdf}

{pdf}images/pdfbook/tosol/resource_en_191525.pdf{/pdf}